



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 16¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“16¹ дүгээр зүйл. Улс төрийн намыг бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

16¹.1. Намыг бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

16¹.1.1. гэрчилгээ олгоход 300 000 төгрөг;

16¹.1.2. намын нэр сольсныг бүртгэхэд 150 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Улс төрийн нам, шашны байгууллагыг” гэснийг “Шашны байгууллагыг” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 15.2.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР